

НИЙГМИЙН ШИНЭЧЛЭЛ-ЦЭРЭГ ИРГЭНИЙ ХАРИЛЦАА

Ч.Эрдэнэчулуун
Социологийн ухааны доктор (Ph.D)

Нийгмийн шинэчлэлийн нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг бол ардчилсан цэрэг-иргэний харилцааны асуудал мөн. Ардчилсан нийгэмгүйгээр ардчилсан зэвсэгт хүчин гэж үгүй. Ардчилсан цэрэг иргэний харилцаагүйгээр ардчилсан нийгэм гэж үгүй.

Ардчилсан нийгмийн цэрэг иргэний харилцааны нэг үндсэн асуудал бол үндэсний аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд "иргэний нийгэм"-ийн оролцоо, дэмжлэг, туслалцааг нэмэгдүүлэх явдал мөн.

Үндэсний аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо идэвхтэй нэмэгдсэнээр нэг талаар иргэний хяналт сайжирах нэг нөхцөл бүрдэж, нөгөө талаар засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналт, хүлээх хариуцлагын хүрээг тэлж өргөжүүлэн энэ чиглэлээр гарч болох сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэх бололцоог бүрдүүлэхэд дөхөмтэй болно.

Иргэний нийгэм нь өвөрмөц сонирхлоороо нэгдэж нийлсэн төрийн үйл ажиллагааны хүрээний гадна сонирхлоо хэрэгжүүлэгч социаль бүрдлүүдийн цогц мөн.¹

Иргэний нийгмийг төрд сөргүүлэн тавьж болохгүй. Иргэний нийгмийн үйл ажиллагаа нь ардчилсан нийгмийн харилцааны нөхцөлд л хэрэгжих бололцоотойн адил ардчилал нь өөрөө бас иргэний нийгмийн баг бэх хөрсөн дээр үүсч хөгждөг байна. Иргэний нийгэм хэдийчинээ хөгжиж чадна, төдийчинээ төрийн ардчилсан хэлбэр тогтон төлөвшиж чадна. Үгөө талаар иргэний нийгэм хэдий чинээ сул хөгжилтэй байна тэнд төрийн засаглалын авторитар, тоталитар дэглэм оршин тогтнох хөрс дэвсгэр нээлттэй байдаг байна.

Иргэний нийгэм хэдийчинээ өргөн хүрээнд аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар оролцож чаднам төдийчинээ цэрэг иргэний харилцаа зөв утгаар хөгжиж төлөвшиж чадна гэж үзэж болох юм. Харин аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгэм төдийлөн идэвхтэй оролцохгүй байгаа тохиолдолд тухайн нийгмийн цэрэг-иргэний харилцаа нь ардчилсан нийгмийн харилцааны агуулга хэлбэрийг бүрэн олоогүй, тухайн оронд засаглалын тогтолцоо төдийлэн үр дүнтэй хэвшиж тогтоогүй гэж үздэг байна.

Ардчилал хөгжсөн орнуудын цэрэг иргэний харилцаанд иргэний нийгэм нь аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлогыг боловсруулах хэрэгжүүлэхэд дараах дөрвөн нийтлэг хэлбэрээр оролцож байна. Тухайлбал:

Нэгдүгээрт, Аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны мэдээлэл ил тод нээлттэйн улмаас энэ чиглэлийн бодлого, үйл ажиллагааны хувилбарыг боловсруулах, тэдгээрийн хэлэлцүүлэгт идэвхтэй оролцох, иргэний нийгэм өөр өөрсдийн чиглэлээр олсон мэдээллийн эх сурвалжаар хангах, судалгаа мэдээллийн лавламж, харьцуулалт бүхий дүн шинжилгээний материалаар хангах зэрэг хэлбэрээр оролцдог.

Хоёрдугаарт, Иргэний нийгэм нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, зохион байгуулалттай болон зохион байгуулалтгүй хурал, уулзалт, зөвөлгөөн, сургалт, судалгааны эх сурвалж, материалыг ашиглах замаар аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны асуудлаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг, маргаан зохион байгуулах, олон нийтийн санал бодлыг судлах, энэ утгаар иргэний нийгмийн энэ салбар дахь хяналтыг өргөжүүлдэг байна.

Гуравдугаарт, Иргэний нийгмийн оролцоо нэмэгдсэнээр иргэний хяналт, гүнзгийрэх, нөгөө талаар аюулгүй байдал болон батлан хамгаалах зарим асуудлаар улс төрийн шийдвэр гаргаж, олон нийтийн дэмжлэгийг авч түргэн шийдвэрлэх боломжийг бүрдүүлдэг байна.

¹ Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2001. 119 х

Дөрөвдүгээрт, Иргэний нийгэм нь аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого үйл ажиллагааны эерэг сөрөг үр дагаврыг хянаж, батлан хамгаалах салбарын хуулийн хэрэгжилт, төсөв, санхүүгийн бүрдүүлэлт, зарцуулалт зэрэг асуудлаар Засгийн газар, Зэвсэгт хүчин бусад хүчний байгууллагуудтай хариуцлага тооцох нэг механизм болдог байна.

Манай орны хувьд бол иргэний нийгэм цэрэг-иргэний харилцаанд оролцох улс төр, эрх зүйн орчин нь нилээд тааламжтай бүрдсэн хэдий ч аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого үйл ажиллагаанд оролцох иргэний нийгмийн идэвх, санаачилга, сонирхол төдийлэн сайн биш байгаа дүр зураг ажиглагддаг.

Энэ нь юун түүрүүнд ардчилсан нийгмийн цэрэг иргэний харилцааг төлөвшүүлэх сургалт, судалгаа, мэдээллийн тархалтыг гүнзгийрүүлэх бодлого, үйл ажиллагаа хомсхон байгаатай холбогдоно.

Иргэний нийгмийг бүрдүүлэгч элементүүдийн дундаас хэвлэл, мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа нь ардчилсан цэрэг-иргэний харилцааг бэхжүүлэхэд онцгой ач холбогдолтой.

Хэвлэл мэдээллийн байгууллага нь аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого үйл ажиллагааны талаар дээр дурьдсан нийтлэг үүргийг хэрэгжүүлэхээс гадна цэрэг иргэний харилцаанд оролцогчид ялангуяа олон нийтийн харилцан бие биенээ ойлголцох талбар болдог. Өөрөөр хэлбэл аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны мэдээллийг иргэний нийгэм, тэдгээрийн идэвхтэн, гишүүд зөвхөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олж мэдэж, өөр өөрсдийн үзэл бодлоо хэвлэл мэдээллээр хариу илэрхийлэх боломж бүрдэнэ гэсэн үг юм.

Мөн хэвлэл мэдээллийн байгууллага нь батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа, батлан хамгаалах төсөв зардал, түүний хэрэгжилтийг олон нийтэд мэдээлж энэ чиглэлийн төсөөллийг бий болгодог. Түүнчлэн аюулгүй байдал, батлан хамгаалах хэрэгцээ шаардлага, тухайн төсөв байдлын талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг өрнүүлэх бололцоог олгож өгдөг. Энэчлэн хэвлэл, мэдээллийн байгууллага нь ардчилсан нийгмийн цэрэг иргэний харилцааг бэхжүүлэхэд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Иргэний нийгмийн цэрэг-иргэний харилцаанд нөлөөлдөг олон хүчин зүйлүүд дотроос зонхилох нөлөөтэй дараах гурван хүчин зүйлийг товч авч үзье.

Тэдгээрт, Нэгд; Цэрэг-иргэний харилцаа түүхэн уламжлалынхаа хувьд ямархуу түвшинд хөгжиж тэр нь хэрхэн уламжлагдаж шинэчлэгдэж ирэв гэдэг нь нилээд суурь хүчин зүйл нь болдог байна. Энэ харилцаанд нь "иргэний нийгэм" ямар оролцоо үүрэгтэй байна вэ? гэдэг нь нэг чухал хүчин зүйл болно.

Улс үндэстний аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн гүйцэтгэх үүргийг түүхэн уламжлал талаас нь авч үзэхийн тулд Зэвсэгт хүчин болон нийгэм хоорондын уламжлалт харилцааг судалж үзэх шаардлагатай. Энэхүү түүхэн уламжлалт харилцаа нь иргэний нийгэмд уламжлагдан хадгалагддаг.

Манай орны хувьд цэрэг-иргэний харилцааны түүхэн уламжлалтай төдийгүй энэхүү харилцаа нь бусад орнуудаас нилээд өвөрмөц онцлогтой, иргэд нь цэргийнхнийг хүндэтгэж бахархах, сэдэл шалтгаантай хэдий ч аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд энд яригдаж буй иргэний нийгмийн оролцоо нь төдийлөн сонгодог хэлбэрээр хөгжиж уламжлан ирж чадаагүй гэж хэлж болно.

Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг нь Европын орнуудын хувьд энэхүү түүхэн харилцаа нь эртний түүхэн уламжлалтай. Тухайлбал Польш, Болгар, Румын зэрэг улсын зэвсэгт хүчин нь тухайн үндэстнийг байгуулагч, нөгөө талаар түүнийг хамгаалж бэхжүүлэгчийн үүргийг зэрэг гүйцэтгэснээрээ нийгэмдээ нилээд үнэ цэнэтэй институт гэж тооцогддог. Тийм ч учир түүхэн уламжлалт харилцааныхаа үүднээс тоталитар дэглэмийн үед эдгээр улсад цэргийнхний нэр хүнд харьцангуй өндөр байсан.

Словак, Латви, Эстоны цэрэг-иргэний харилцаа нь тоталитар нийгмийн харилцаанаас ч улам бүр дордсон. Учир нь эдгээр улсууд зэвсэгт хүчнийг мэргэжлийн утгаар нь шинээр байгуулсантай холбогдоно. Үүнд нь улс орны эдийн засгийн хямрал нь давхар нөлөөлсөн байж ч болох юм.¹

Хоёдугаарт, Аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны гадаад, дотоод орчны өөрчлөлтөөс үзүүлэх нөлөөлөл багтдаг. Эдгээр өөрчлөлтийн явцад "Иргэний нийгэм"-ийн оролцоо ямар түвшинд хүрдэг нь ч нэг чухал хүчин зүйл байдаг.

Гадаад, дотоод орчны өөрчлөлт нь үндэсний аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд стратегийн шинжтэй өөрчлөлтийг шаардана. Тоталитар дэглэмийн сүйрэл болон ардчилсан шилжилт нь манай орны болон Европын орнуудын аюулгүй байдлын орчинг бүхэлд нь өөрчилсөн.

Мөн 2002 оны 9 дүгээр сарын 11-нд АНУ-д болсон террорист халдлага нь улс орон бүрийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд шинэ стратегийг бий болгосон.²

Энэ үйл явдлын дараа дэлхий нийтээрээ, улс орнууд тэдгээрийн иргэний нийгмийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд оролцох оролцоо улам бүр идэвхжих хандлагатай боллоо.

Улс орнууд гадаад дотоодод гарсан стратегийн өөрчлөлттэй уялдуулан зэвсэгт хүчнийхээ бүтэц зохион байгуулалтыг өргөтгөж улам бүр чадваржуулах, цэргийн түншлэл, холбоонд гишүүнээр элсүүлэх гээд олон чиглэлээр ажиллах боллоо. Энэ бүхэн нь иргэний нийгмийн оролцоог зайлшгүй шаардаж байна.

Тухайлбал Латви, Литви, Эстони улсууд НАТО-гийн гишүүн болох санал нь олон түмнийхээ дэмжлэгийг хүлээсэн бөгөөд ингэснээр иргэний нийгмийн дунд аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын асуудлаар маргаан, хэлэлцүүлэг олон түмний дунд өрнөх болсон байна. НАТО-гийн зүгээс тус орны хэвлэл мэдээллийн болоод төрийн бус байгууллагуудтай энэ асуудлын талаар хамтын ажиллагааг олон арга хэлбэрээр өрнүүлэх болжээ.³

Мөн Чех, Румын, Литви зэрэг орнууд зэвсэгт хүчнээ бага зэрэг өргөтгөн зохион байгуулсан бол Словакийн хувьд зэвсэгт хүчнээ олон улсын энхийг сахиулах, гамшиг, хямралын үед иргэний удирдлагыг дэмжих, уламжлалт бус аюултай тэмцэх зэрэг үүргээр бэлтгэх болжээ.

Европын орнуудад үндэсний аюулгүй байдлын стратегид цэргийн бус хүчнийг ашиглахад ихээхэн ач холбогдол өгч байна. Энэ орнуудад Батлан хамгаалах яам, зэвсэгт хүчин, аюулгүй байдлын байгууллагууд, парламентын байнгын хороод буюу энэ асуудлаарх төрийн бус иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэх арга замыг эрэлхийлж байна.⁴

Гуравдугаар хүчин зүйл нь тухайн нийгмийн харилцаанд ардчилал хэр зэрэг хөгжиж байна. Тэр тусмаа иргэний нийгэм аюулгүй байдал болон батлан хамгаалах үйл ажиллагаанд оролцох хэр зэрэг боломжтой байна гэдэг асуудал юм. Манай орны хувьд иргэний нийгэм аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд оролцох улс төр, эрх зүйн болон нийгмийн үзэл санааны орчин нөхцөл сайтар бүрдсэн хэдий ч иргэний нийгмийн энэ чиглэлийн бодлого, үйл ажиллагаанд оролцох оролцоо төдийлөн сайнгүй байгаа нь амьдралаас ажиглагдаж байна. Тийм учир юун түрүүнд төр засгийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд оролцдог байгууллагуудын мэдээллийг иргэний нийгмийн хүрээнд өргөн түгээх, тэдгээр байгууллага, иргэдэд дэмжлэг үзүүлэх явдал мөн.

Европын орнуудын цэрэг-иргэний харилцаанд хийсэн судалгааны дүнгээс харахад цэрэг-иргэний харилцааны шинэчлэл нь ерөнхийдөө нийгмийн харилцааны шинэчлэлээс ихээхэн

1 Edmunds, Dr Timony. Security sector Reform Concepts and implementation. Report for Geneva Centre for Democratic control of Armed Forces 20-22. November. 2001 (2-3)

2 Цэрэг иргэний харилцааны тулгамдсан асуудал. 2002

3 Edmunds, Dr Timony. Security sector Reform Concepts and implementation. Report for Geneva Centre for Democratic control of Armed Forces 20-22. November. 2001 (2-3)

4 Edmunds, Dr Timony. Security sector Reform Concepts and implementation. Report for Geneva Centre for Democratic control of Armed Forces 20-22. November. 2001 (2-3)

хамааралтайн сацуу цэрэг иргэний харилцааны шинэчлэл үндсэн хоёр үе шаттай явагддаг болох нь харагдаж байна.¹

Европын орнуудын цэрэг иргэний харилцааг судалдаг эрдэмтэд шинэчлэлийн хоёр үе шатны үйл явцыг харьцуулан судлаад хоёрдугаар үе шатны цэрэг-иргэний харилцаанд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх таатай орчин нөхцөл нь бүрддэг тухай тэмдэглэсэн.

Тэдгээр судлаачид тэмдэглэхдээ цэрэг-иргэний харилцааны шинэчлэлийн нэгдүгээр үе шатанд цэрэг-иргэний харилцааны үндэс суурь тавигдах төдийгүй ихэнхдээ бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл явагддаг гэжээ.

Тухайлбал эрх зүйн хүрээнд аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлыг хариуцдаг засгийн газрын байгууллагуудын удирдлагын эрх мэдлийг зааглах, цэргийн мэргэжлийн удирдлагыг тусгаарлах, зэвсэг хүчинд тавих иргэний хяналтын механизмыг бүрдүүлэх, Батлан хамгаалах бодлого, төсвийн бүрдүүлэлт, зарцуулалт, хуваарилалтыг хянах, улс орны аюулгүй байдлыг батлан хамгаалах асуудлаархи үүргийг төрийн захиргааны болон цэргийн мэргэжлийн удирдлагын хүлээх үүрэг хариуцлагыг хуваарилах, цэрэгжсэн байгууллагын удирдлагыг иргэншүүлэх, цэргийн байгууллагын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаардаг байна.

Нөгөө талаар судлаачид нэгдүгээр үе шатны зорилт нь шинэчлэлийн эцсийн хүлээх үр дүнг хэрэгжүүлж чадахгүй гэж үзжээ.

Харин шинэчлэлийн нэгдүгээр үе шатны бий болсон харилцааг хоёрдугаар үе шатанд цаашид улам бүр бэхжүүлэх өөрөөр хэлбэл бүтэц зохион байгуулалтыг улам бүр гүнзгийрүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэх, хяналт, хариуцлагыг дээшлүүлж, ил тод байдлыг нэмэгдүүлэх, мэргэжлийн болоод байгууллагын үйл ажиллагааг чадваржуулах, эцэст нь иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх бололцоо бүрддэгийг тэмдэглэжээ.

Нөгөө талаар тэдгээр судлаачид цэрэг-иргэний харилцааны шинэчлэлийн хоёрдугаар шатанд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхийг онцгойлон авч үзсэн байна. Судлаачид цэрэг-иргэний харилцаанд иргэний нийгмийн оролцоо хязгаарлагдмал байх нь зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтын ач холбогдлыг бууруулж байгаа хэрэг гэж тэмдэглэсэн.

Цэрэг-иргэний харилцааг судалж байгаа судлаачдын үзэж байгаагаар авч үзэх юм бол манай орны хувьд шинэчлэлийн нэгдүгээр үе шатнаас хоёрдугаар үе шатанд шилжих шилжилтийн нөхцөлд байна гэж үзэж болно. Гэхдээ манай орны хувьд аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт зарцуулсан хөрөнгөнд нарийвчилсан мэдээлэл хомсхон, энэ талаарх бодлого үйл ажиллагааны хувилбаруудад дүн шинжилгээ хийх нь өнгөцхөн бөгөөд тодорхой цөөхөн албан тушаалтны дунд стратегийн болон нөөцийн уялдаа холбоо тааруухан, шинэчлэлийн бодлого, үйл ажиллагаа тууштай бус зэрэг сөрөг хандлага байгааг анхаарахгүй байж болохгүй.

Цэрэг-иргэний харилцааг нийгмийн шинэчлэлтэй уялдуулан цаашид боловсронгуй болгох үүднээс дараах санал дүгнэлтийг хийж болно.

Нийгмийн шинэчлэлийн нэг чухал асуудал нь цэрэг иргэний харилцааны асуудал мөн. Цэрэг иргэний харилцааг ардчилсан нийгмийн харилцааны нийтлэг жишиг хандлагаар хөгжүүлэхэд аюулгүй байдал батлан хамгаалах бодлого боловсруулах хэрэгжүүлэх үйл ажиллагаанд "иргэний нийгмийн" оролцоог нэмэгдүүлэх явдал юм. Хэрвээ иргэний нийгэм нь аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого үйл ажиллагааг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож чадахгүй тохиолдолд цэрэг-иргэний зохисгүй харилцаа үүсч, сайн засаглал бэхжихгүй шинэчлэл удаашрах болдог байна. Тийм учраас юун түрүүнд аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх сургалт судалгааны ажлын өнөөгийн түвшинг шинэ агуулга хэлбэрээр баяжуулж, төр, засгийн болон иргэний нийгмийн зүгээс санхүү хөрөнгийн төдийгүй эрх зүй, удирдлага зохион байгуулалтын өргөн дэмжлэгийг бий болгох шаардлагатай санагдана.

¹ Cottey, Andrew The second Generation problematic. Rethinking Democratic control of Armed Forces in Central and Eastern Europe. Htt. Civil. Military.dsd.kcl.ac.uk